



МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/49

Улаанбаатар хот

«Экспорт, импорт, хилийн хорио цээрийн
хяналтын хуудас батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар заалтын 5.7, 9 дүгээр зүйлийн 9.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хилийн хорио цээрийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэх шинээр боловсруулсан 9.1.3, 9.1.4, 9.1.5, 9.3.1, 9.3.10, 9.3.11, 9.4.1.3, 9.4.1.4 хяналтын хуудсыг нэгдүгээр хавсралтаар, шинэчлэн боловсруулсан 9.1.1, 9.1.2, 9.2.1, 9.2.2, 9.2.3, 9.3.1, 9.3.2, 9.3.3, 9.3.4, 9.3.5, 9.3.6, 9.3.7, 9.3.8, 9.3.9, 9.4.1.1, 9.4.1.2, 9.4.2, 9.4.3, 9.5, 9.4.4.1, 9.4.4.2, 9.4.5, 9.4.6, 9.4.7 кодтой хяналтын хуудсыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан хяналтын хуудсуудыг хяналт шалгалтад хэрэглэх, улсын байцаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газар, боомт дахь Хилийн Мэргэжлийн хяналтын алба, хэлтэс, аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтсийн Эрсдэлийн удирдлага, стратеги төлөвлөлтийн газар, аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Хяналтын хуудас шинэчлэн баталсантай холбогдуулан Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2014 оны 309 дүгээр тушаалын 2-р хавсралтын "Импортын барааны хяналтын хуудас"-ны 9.1.1, 9.1.2, 9.2.1, 9.2.2, 9.2.3, 9.3.1-9.3.6, 9.4.1.1-9.4.1.2, 9.4.2, 9.4.3, 9.5 кодтой, 2014 оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан 9.3.7, 9.4.4.1, 9.4.4.2, 9.4.5, 9.4.6, 9.4.7, 2015 оны 540 дугаар тушаалаар баталсан 9.3.8, 9.3.9 кодтой хяналтын хуудсыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Хяналтын хуудасны ашиглалт, хяналт шалгалтын явц, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, дүн шинжилгээ хийсэн байдалд хяналт тавьж ажиллахыг Эрсдэлийн удирдлага, стратеги төлөвлөлтийн газар /М.Наранбат/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ЦАГААНХҮҮ